

“МНТ”-ны зарим шүлгийн хятад орчуулгад хийсэн ажиглалт

Г.Элдэв-Очир* (МУИС)

Abstract: It is very important to satisfy proper assonance between style and meaning of poetry in its translation. Depending on the language specification rhythm and consonant of the poetries are various. So how to render that while keeping everything in the translation is complicated. In this article we compared style and meaning of some poetry in the Mongolian Secret History with its Chinese translation.

Key words: *Mongolian Secret History, poetry translation, literature translation, Chinese translation*

Уран зохиолын орчуулга судлал эрчээ аван хөгжсөөр багагүй хугацааг үдлээ. Уран зохиолын орчуулгад шүлэг, яруу найргийн орчуулга нэлээд хэцүү, ярвигтайд тооцогддог боловч үе үеийн орчуулагчид өөр өөрийн арга барил, өнгө төрхөөр дуун хөрвүүлсээр өнөөг хүрчээ. Шүлэг нь айзам хэмнэл, толгой сүүл холбох, мөр шадын үеийн тоо тэнцүү байх гэх мэт нарийн бүтэцтэй тул орчуулгад хүүрнэл зохиол шиг үгийг чөлөөтэй сонгох боломжоор хомс байдаг. Манай нэрт яруу найрагч Б.Явуухулан “Яруу найргийн орчуулгын асуудалд” хэмээх өгүүлэлдээ, яруу найргийн орчуулгад эрхэмлэвэл зохих 4 зүйл бий. Үүнд: 1. Санааг тод буулгах 2. Дүр, зураглалын өвөрмөц нарийнийг хадгалах 3. Шүлгийн өнгө аяс, хөгжмийг хадгалах 4. Шүлгийн хэлбэрийг хадгалах хэрэгтэй гэжээ. /Д.Дашдаваа, 1988:64/ Үүнээс үзэхэд, шүлгийн орчуулгад агуулга, хэлбэрийн зохицол, хэм хэмжээг нарийн тохируулах нь туйлын чухал болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, агуулга, хэлбэрийн аль нэгийг омтгойлох аваас эх зохиолоос холдон хөндийрдөг аж. Шүлэг, яруу найраг нь тухайн хэлний онцлогт тохирсон айзам хэмнэл, бүтэцтэй байдаг бөгөөд “МНТ”-ны шүлэг ч мөн ийм байдлаар бичигдсэн байдаг. “МНТ”-г олон хэлэнд орчуулсан байдгаас, зөвхөн хятад хэлэнд зургаан орчуулагч өөр өөрийн арга барилаар орчуулжээ. Тэдгээрийн нэг нь орчуулагч Сизэ Зайшан бөгөөд тэрээр Ц.Дамдинсүрэн гуайн 1947 онд хэвлүүлсэн “МНТ”-г 1956 онд орчуулан Шанхайд хэвлүүлжээ. Уг орчуулгыг ерөнхийд нь авч үзвэл, эхийг ягштал сайн баримтлан, утгачилах, үгчилэх хоёр аргыг чадамгай хослуулсан байна. Харин бид энэхүү өгүүлэлдээ “МНТ”-ны зарим шүлгийг уг орчуулгад хэрхэн хөрвүүлснийг харьцуулан үзэхийг оролдлоо.

“МНТ”-ны 27 зүйл: Эх зохиол

*МУИС-ийн ГХСС-ийн Хятад судлалын тэнхим, дэд профессор, доктор

1. Мөчир бүрээс
2. Мөч гуя өлгөж
3. Хожуул бүрээс
4. Хоёр гурван шувуу өлгөсөн нь ялзрахад хүрчээ.

Хятад орчуулга:

1. 每一个干树枝上
 2. 都挂着野兽的后腿
 3. 每一个枯树枝上
 4. 都挂着两三个野鸟
- 有的都腐败了。

Орчуулгын эхийн үгчилсэн орчуулга:

1. Хуурай модны мөчир бүр дээр
2. Араатан амьтаны гуя өлгөж
3. Хувхай модны мөчир бүр дээр
4. Хоёр гурван шувуу өлгөсний зарим нь ялзарлаа.

“МНТ”-ны 27-р зүйлд буй энэхүү шүлгийн орчуулгад хэлбэрийн талаас 1-3 мөр, 2-4 мөрийн толгойг салаавчлан холбож, мөрийн үеийн тоог 7-8, 7-8 байдлаар мөн л салаавчлан тэнцүүлж, хятад шүлгийн айзам, хэмнэлийн зарчмыг баримталсан боловч агуулгын хувьд эхээсээ ташаа болсон зарим зүйл ажиглагдлаа. Уг шүлгийн 2-р мөрд буй “...Мөч гуя өлгөж...” гэдгийг “...Араатан амьтны гуя өлгөж...” хэмээн утгыг нэмэн дэлгэрүүлэн тодотгохыг оролдсон боловч уг зүйлийн хам сэдвийн утгыг анхаараагүй бололтой. Учир нь, “МНТ”-ны 27-р зүйлд: “Хавар болж, нугас ирэх цагт харцагаа сойж тавиад галуу, нугас олныг алж, идэж үл барах тул

Мөчир бүрээс

Мөч гуя өлгөж

Хожуул бүрээс

Хоёр гурван

шувуу өлгөсөн нь ялзрахад хүрчээ.” гэжээ. Энд галуу, нугасны мөч, гуя өлгөх тухай дурдсанаас араатан амьтны гуя өлгөх тухай огт хэлээгүй болох нь тодорхой байна. Иймд орчуулагч үүнийг эндүү ойлгон ийнхүү ташаа орчуулжээ. Мөн эх зохиолын 3-р мөрийн “хожуул” гэдгийг хятад хэлний “枯树” буюу “хувхай мод”-оор орчуулсан нь мөн л ташаа болжээ.

“МНТ”-ны 113 зүйл: Эх зохиол

1. Эцэг хан Тоорил
2. Эрхэм анд Жамуха нар
3. Эв хүчийг нэгтгэж
4. Эрхт тэнгэрийн өршөөлөөр
5. Эх дэлхийн ивээлээр
6. Эртний өшөөт мэргидийн

7. Элэг зүрхийг эмтэлж
8. Эрхэм төрлийг сөнөөж
9. Эзэмших гэрийг хоосолж
10. Элдэв зүйлийг олзлов.

Хятад орчуулга:

1. 脱韩邻勒罕父
2. 札木合安答
3. 同心协力
4. 上天的仁慈
5. 神人的保佑
6. 把世仇蔑儿乞惕的
7. 心肝挖出来
8. 消灭了他们的族类
9. 扫空了他们的居屋
10. 掳掠了他们的一切。

Орчуулгын эхийн үгчилсэн орчуулга:

1. Тоорил хан эцэг
2. Жамуха анд
3. Сэтгэлээ нэгтгэж хүчээ хамтатгаж
4. Дээд тэнгэрийн өршөөлөөр
5. Сахиус онгодын ивээлээр
6. Эртний өшөөт мэргидийн
7. Элэг зүрхийг ухан гаргаж
8. Овог угсааг нь устгаж
9. Орон байрыг нь хоосолж
10. Юм бүгдийг нь булаав.

Энэ шүлгийн 2-р мөрөнд буй “Жамуха анд”-ын “анд” хэмээх үгийг орчуулагч хятад хэлнээ “安答/anda” гэж авиачлан авсан нь сонирхолтой санагдаж байна. Учир нь монгол хэлний “анд” хэмээх үгийн утгыг орчуулан дүйцүүлэх буюу “тэнцүү чанар”-тай үг хятад хэлэнд мэдээж буй. Гэтэл орчуулагч энэхүү “анд” хэмээх үгийг “Тоорил хан эцэг” гэдэг шиг хэргэм цолны нэр буюу монгол хэлний үндэсний онцлог бүхий үг хэллэг байх хэмээн тааварлан ойлгосноос үүдэн ийнхүү хэвээр хэрэглэсэн болтой юм. Мөн уг шүлгийн 3-р мөрний “Эв хүчийг нэгтгэж” гэдгийг хятад хэлний “同心协力” буюу “сэтгэлээ нэгтгэж, хүчээ хамтатгах” гэсэн хэвшмэл хэллэгээр, 5-р мөрний “эх дэлхийн ивээлээр” гэснийг “Сахиус онгодын ивээлээр” хэмээн утгачлан орчуулсан нь эхийн утга санаатай бараг дүйжээ. Ерөнхийд нь авч үзвэл, энэхүү шүлгийн утгыг голлон анхаарч ягштал сайн орчуулсан боловч, хятад шүлгийн холбоц болон айзам хэмнэлийг төдийлөн чухалчлаагүй байна.

“МНТ”-ны 124 зүйл: Эх зохиол

1. Алаг сайхан хоньдыг
2. Ар дүүрэн бэлчээж
3. Хонин олон сүргийг
4. Хот дүүрэн өсгөж
5. Ховдог төрсөн би чинь

6. Хос цувдай хүртэж
7. Хошгиног мах идэж
8. Өдөр тутам өнжихгүй
9. Хоног тутам хожимдохгүй
10. Шилдэг иргийг алж
11. Шимтэй шөлийг бэлтгэж явъя.

Хятад орчуулга:

1. 把美好的羊
2. 牧放得肥胖
3. 把成群的羊
4. 繁殖的满野。
5. 生而好吃东西的我
6. 供你饮食不断。
7. 肥肠白肉
8. 每日无缺
9. 每夜不误。
10. 宰杀好羯羊
11. 给你准备好饮汤。

Орчуулгын эхийн үгчилсэн орчуулга:

1. Сайхан хонийг
2. Таргалуулан маллаж
3. Сүрэг хонийг
4. Тал дүүрэн өсгөө.
5. Идэмхий төрсөн би
6. Идэх хоолыг чинь хангаж байя.
7. Хос цагаан мах /гургалдай/-ыг
8. Өдөр тутам хоцроохгүй
9. Үдэш бүр саатуулахгүй байя.
10. Сайн иргийг алж
11. Сайхан шөлийг нь чамд бэлтгэж байя.

Энэхүү шүлгийн 1-р мөрийн “алаг сайхан хоньдыг” гэснийг зүгээр л “сайхан хонийг” хэмээн ерөнхийлөн орчуулжээ. Учир нь монгол хүний сэтгэлгээнд алаг сайхан хоньд гэхэд шууд л бууна. Харин хятад хүний сэтгэлгээнд төдий л сайн буухгүй учир “алаг” гэснийг орхиж “сайхан хонь” гэдгээр орчуулжээ. Харин 2-р мөрний “ар дүүрэн бэлчээж” гэснийг “таргалуулан маллаж” хэмээн утгачилжээ. Мөн 4-р мөрний “хот дүүрэн өсгөж” гэснийг “Тал дүүрэн өсгөө” хэмээн орчуулжээ. Хятадад “хот” хэмээх ойлголт байхгүй учир “тал” гэж буулгажээ гэж тайлбарлаж болох боловч хятад хэлэнд “хот” гэдэгтэй дүйцэх “羊圈” гэх үг бий. Орчуулагч энэхүү үгээр орчуулалгүй “тал” гэх утгатай үгээр орчуулсан нь магадгүй хүч нэмэгдүүлэх, эх зохиолд буй санааг илүү лавшаруулан ойлгосоноос үүдэлтэй байж болох талтай байна. Учир нь монголчуудын билэгдэлд амьдрал ахуйн үндэс болсон мал сүрэгээ үргэлж тал дүүрэн өсгөж үржүүлэх тухай байдаг билээ. Тухайлбал, ...тал дүүрэн малтай билээ, тараг айраг элбэгтэй билээ... хэмээн шүлэглэсэн нь бий. Энэ үүднээс авч үзвэл, орчуулагч эх зохиолд буй мал сүргээ өсгөх монгол хүний билэгдлийн талаас орчуулгадаа анхаарчээ гэж үзэх үндэслэлтэй байна. Мөн эхийн 6, 7-р мөрний “Хос цувдай хүртэж, Хошгиног мах идэж” гэснийг

“Хос цагаан махыг” хэмээн нэг мөрөнд нэгтгэж, 6-р мөрөнд “идэх хоолыг чинь хангаж байя” гэсэн эхэд байхгүй санааг нэмж гарган шүлгийн мөрийн тоог гүйцээжээ. Уг орчуулгад 1-3 мөрийн толгой, сүүлийг салаавчлан холбож, 8-9 мөрийн толгой холбон хятад шүлгийн айзам хэмнэлийн зарчмыг баримталжээ. Ерөнхийд нь авч үзвэл, энэхүү шүлэг нь монгол үндэсний соёл, сэтгэлгээтэй нягт холбоотой, үндэсний онцлог бүхий үг, хэллэг нэлээд орсон тул орчуулгын хувьд ярвигтай байх нь дамжиггүй. Харин орчуулагч утгачилах болон үгчилэх аргыг хослуулан басхүү чадамгай орчуулжээ.

“МНТ”-ны 147 зүйл: Эх зохиол

1. Алъя гэвэл ал
2. Алганы төдий газрыг
3. Алаг болгож үмхийрүүлэх
4. Алд бие байна,
5. Аваръя гэж санаад
6. Амий минь соёрхвол
7. Халд гэсэн газарт чинь
8. Харайж очоод би
9. Хар усыг цалгитал
10. Хад чулууг хэмхэртэл
11. Харь дайсныг довтолж
12. Хаан чамд тусалъя.
13. Цээлийн усыг цалгитал
14. Цэгээн чулууг хагартал
15. Чин зоригийг гаргаж,
16. Чингис чамд тусалъя.
17. Хүр гэсэн газарт чинь
18. Хүрч очоод би
19. Хүр чулууг хэмхэлье
20. Хүний зүрхийг шанталъя.

Хятад орчуулга:

1. 杀就杀
2. 你杀我
3. 不过是浅污了
4. 像手掌大的一块地皮。
5. 倘若饶我
6. 赐我一命
7. 赴汤蹈火
8. 我也愿意。
9. 横断黑水
10. 粉碎岩石
11. 扶保合罕。
12. 征讨外敌
13. 横断深渊
14. 粉碎坚石
15. 全心全意
16. 扶佐合罕。

17. 叫我到那里
18. 我就到那里
19. 去粉碎坚石
20. 去挖取人心。

Орчуулгын эхийн үгчилсэн орчуулга:

1. Алъя гэвэл ал
2. Чи намайг албал
3. Алгын чинээ газрыг
4. Алаглуулах төдий билээ.
5. Хэрэв намайг өршөөж
6. Амь нас хайрлавал
7. Аюул зовлонгоос зайлахгүйг
8. Харин би хүснэ.
9. Хар усыг хөндлөн огтолж
10. Хад чулууг бут цохиж
11. Хаан таныг түшин хамгаална.
12. Харь дайсныг дайлж
13. Цүнхээл усыг туучиж
14. Хад чулууг бут цохиж
15. Хамаг сэтгэл зүрхээрээ
16. Хаан танд түшин туслана.
17. Тэнд хүр гэвэл
18. Тэнд би хүрч
19. Хад чулууг хэмх цохиж
20. Хүний зүрхийг гаргаж хаяна.

Энэхүү шүлгийн орчуулгад 2-р мөрийн “Чи намайг албал” гэдгийг нэмж оруулжээ. Мөн эхэд буй 7-8 мөрийн “Халд гэсэн газарт чинь, харайж очоод би” гэснийг “赴汤蹈火, 我也愿意” буюу “Аюул зовлонгоос зайлахгүйг, Харин би хүснэ” хэмээн ерөнхий санааг утгачилан орчуулжээ. Эх зохиолд буй утга санаа нь 7-20 мөр нь Зэвийн амь өршөөгдвөл цаашид юу хийж чадахаа амлаж буй ам тангараг юм. Энэ нь 7-12 мөр, 13-16 мөр, 17-20 мөр гэсэн шүлгийн хэмнэл, бүтцээр утга санаа нь багцлагдсан байна. Орчуулгад энэхүү хэмнэлийг 7-8 мөр, 9-11 мөр, 12-16 мөр, 17-20 мөр гэсэн бүтцээр зарим мөрийг дээр, доор холин орчуулсан боловч, 17-20 мөрд утга санаа болон айзам хэмнэл нь бүрэн гүйцэд гарчээ.

Дээрхээс дүгнэж үзвэл, манай орчуулгын судлалд харь хэлнээс монгол хэлэнд орчуулсан зохиолыг түлхүү судалж ирсэн бөгөөд харин монгол хэлнээс харь хэл рүү орчуулсан зохиолын талаар төдий л сайн судлагдахгүй байгааг анхаарах цаг болжээ. Өөрөөр хэлбэл, монгол хэлнээс харь хэл рүү орчуулсан орчуулгыг судласнаар монгол зохиолын утга санаа, айзам хэмнэл, яруу тансаг байдлыг гадны орчуулагчид хэрхэн оноон буулгасныг судлан, алдаа дутагдлыг нь нээн илрүүлж шүүмжлэхээс гадна, хоёр хэлний зэрэгцүүлсэн судалгаа хийх сайхан үндэс суурь болох юм. Иймд цаашид энэ чиглэлийн судалгааг эрчимжүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэе.

Ном зүй

1. Дамдинсүрэн.Ц, Монголын нууц товчоо, Улаанбаатар, 1990
2. Дашдаваа.Д, Уран зохиолын орчуулгын тухай, Улаанбаатар, 1988
3. Хүрэлбаатар.Л, Монгол орчуулгын товчоон, Улаанбаатар, 1995
4. Сиз Зайшан, Монголын нууц товчоо, Шанхай, 1956
5. Цао Минлюн, Орчуулга: онол хийгээд дадлага, Хөбэй, 2007